



“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ

ТЕХНИКҮҮДИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТ ЗАСВАР,  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ  
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ  
БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

Техникүүдийн төлөвлөгөөт засвар, үйлчилгээний ажил

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

МРЦМ/20240101296

2024 он

## **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА**

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА .....	3
II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ .....	15
III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	19
IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	4
V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ .....	5
VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ .....	12

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

### А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1. Тендерийн цар хүрээ**
- 1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “ажил” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 1.2.Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 1.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг**
- 2.1.Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана.
- 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж**
- 3.1.Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 4. Худалдан авах ажиллагааны цахим систем**
- 4.1.Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.
- 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх**
- 5.1.Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.
- 5.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага**
- 6.1.Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.

6.4. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5. Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6. Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

## **7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага**

7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

## **Б. АГУУЛГА**

## **8. Тендер шалгаруулалтын баримт бичиг**

8.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд

нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3. Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

## **9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**

9.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2. Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

## **10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

## **11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

## **В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**

## **12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон**

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл

## **тендерийн хэл**

хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

## **13. Тендерийн иж бүрдэл**

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;

13.2.8.ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9.Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3.Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4.Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

#### **14. Тендерийн жишиг маягууд**

14.1.Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

#### **15. Хувилбарт санал**

15.1.Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

#### **16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг**

16.1.Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2.Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2.Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1.хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2.гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3.тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3.Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4.Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т

**17. Чадавхын болон туршлагын шаардлага**

заасан баримт бичиг ирүүлнэ.

17.1.Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2.Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3.Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4.Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5.Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

**18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**

18.1.Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2.Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3.Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4.Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

**19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**

19.1.Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2.Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3.Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл



гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4.ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

**20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**

20.1.Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2.III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3.Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

**21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**

21.1.Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2.Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.

21.3.Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.4.ТШЗ-ны 21.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.

21.5.ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.6.Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.7.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах

хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

## **22. Тендерийн валют**

22.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

## **23. Тендер хүчинтэй байх хугацаа**

23.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1.Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2.Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

## **24. Тендерийн баталгаа**

24.1.Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2.Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.3.Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

## **Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**

## **25. Тендер баталгаажуулах, илгээх**

25.1.Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2.ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3.Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягыг ТШЗ-ны 25.1-д зааснаар

тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт **Error! Reference source not found.**7-ын д агуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5.Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

## **26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

26.1.Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2.Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

## **Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**

### **27. Тендерийн талаар тодруулга авах**

27.1.Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

### **28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

### **29. Тендерийг үнэлэх**

29.1.Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйл, Сангийн сайдын “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу үнэлж, харьцуулна.

### **30. Арифметик алдааг залруулах**

30.1.Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

### **31. Давуу эрх олгох**

31.1. Захиалагч нь хуулийн 8.4, 8.7-д зааснаар давуу эрх олгоход оролцогчийн ирүүлсэн нотлох баримтыг үндэслэн хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу үнийг хийсвэрээр бууруулж тооцно.

**32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**

31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.

32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

**33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**

33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:

33.1.1. ТШЗ-ны 21.1-д зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;

33.1.2. ТШЗ-ны 21.5-д заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцох;

33.1.3. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;

33.1.4. ТШЗ-ны 29.1.1, 29.1.2, 29.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 22.1-д заасан валютад хөрвүүлэх;

33.1.5. ТШЗ-ны 31.1-д зааснаар давуу эрх олгох;

33.1.6. ТШЗ-ны 32.1-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.

33.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална:

33.2.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгох;

33.2.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 35-д зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;

33.2.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ

байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.

- 33.3. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.
- 33.4. ТШЗ-ны 33.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх** 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах** 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.
- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18.1-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19.1-д заасан техникийн чадавх, туршлага, гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. Оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

#### **Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

- 36. Мэдэгдэл хүргүүлэх** 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
- 37. Гүйцэтгэлийн баталгаа** 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38. Урьдчилгаа төлбөр** 38.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр

олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

38.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.

38.3. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.

**39.Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**

39.1. Захиалагч VI бүлгийн гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

39.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

39.3. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

39.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

<b>ТШЗ-ны холбогдох заалт</b>	<b>А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
<b>ТШЗ 1.1</b>	Захиалагч: <b>“Монголросцветмет” Төрийн өмчит үйлдвэрийн газар</b>
<b>ТШЗ 1.1</b>	Тендер шалгаруулалтын нэр: <b>Техникүүдийн төлөвлөгөөт засвар үйлчилгээний ажил</b>
<b>ТШЗ 1.1</b>	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: <b>МРЦМ/20240101296</b>
<b>ТШЗ 1.2</b>	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцтай</b> <b>Багц №1: Terex TR60 автосамосвал, LIEBHERR R9100, R976, R966, R924 экскаватор, PR776 бульдозер техникүүдийн төлөвлөгөөт засвар үйлчилгээ</b>
<b>ТШЗ 1.3</b>	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: <b>“Үгүй”</b>
<b>ТШЗ 2.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>“Монголросцветмет” ТӨҮГ өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.</b>
<b>ТШЗ 2.1</b>	Нийт төсөвт өртөг: <b>5 742 320 000 төгрөг</b> Багц №1 <b>4 636 400 000 төгрөг</b>
<b>Б. АГУУЛГА</b>	
<b>ТШЗ 7</b>	Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага Туслан гүйцэтгэгч, түншлэл нь 7.1-с 7.5-н заалтын тавигдах шаардлагыг хангасан байна.
<b>ТШЗ 9.1</b>	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид: <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системээр авна. Хүлээн авагчийн нэр: <b>“Монголросцветмет” ТӨҮГ.</b> Хаяг: <b>УБ хот, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 98, 22-р хороо, Утасны дугаар: 976-11-450060, Цахим шуудангийн хаяг: mailbox@monros.mn</b>
<b>ТШЗ 10.1</b>	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <b>“Үгүй”</b>
<b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>ТШЗ 12.1</b>	Тендер шалгаруулалтын хэл: <b>Монгол хэл.</b>
<b>ТШЗ 15.1</b>	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>“Зөвшөөрөхгүй”</b>
<b>ТШЗ 16.1.2</b>	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: <b>“Шаардана”</b> 1. ТШББ-ийн V бүлэг дэх маягтуудын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ. 2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ /цахимаар/, НӨАТ төлөгчийн гэрчилгээ,

	<p>3. Оролцогч, түншлэгч нь тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системтэй холбогдсон мэдээллийн сангаас дараахь мэдээллүүдийг цахим системээр дамжуулан татан авч, тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө уг цахим системийн холбогдох хэсэгт зааварчилгааны дагуу холбон баталгаажуулж илгээнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- татвар төлөлтийн тодорхойлолт.</li> <li>- шүүхийн тодорхойлолт, шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөртэй эсэх тодорхойлолт.</li> </ul>
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: <b>“Шаардана”</b>  <b>Хэрэв шаардах бол дор дурдсан шаардлагаас гэрээний үүргийн гүйцэтгэлд ач холбогдол бүхий доод шалгуур үзүүлэлт, шаардлагыг тусгах ба үүгээр хязгаарлагдахгүй.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>Борлуулалтын орлогын хэмжээ: 2022, 2023 оны жил тус бүрд гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь багц №1-н батлагдсан төсвийн 100 хувиас багагүй байх.</b></li> </ul>
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үнэлгээнд харгалзах санхүүгийн тайлангийн хугацаа; 2022, 2023 онууд</li> <li>- Харилцагч банкны мэдэгдэл; Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшхи өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа;</li> <li>- сүүлийн хоёр хүртэл жилийн хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан;</li> <li>- сүүлийн хоёр хүртэл жилийн хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл.</li> </ul>
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: <b>“Шаардана”</b>  <b>Ажил гүйцэтгэх хүний нөөц: “Шаардахгүй”</b>  <b>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “Шаардахгүй”</b></p> <p>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: <b>“Шаардана”</b>  <b>Багц №1-н батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг 2022, 2023 оны жил тус бүрд доод тал нь 1 удаа гүйцэтгэсэн байх.</b>  <b>Ижил төстэй ажил гэж “уул уурхайн машин, тоног төхөөрөмж болон дагалдах сэлбэг эд анги, материалыг худалдан борлуулсан, дагалдах үйлчилгээг үзүүлж байсан” гэж ойлгоно.</b>  <b>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардана”</b>  <b>Оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг V-р бүлгийн маягт 5-н дагуу</b></p>
ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> <li>- <i>Liebherr</i> маркийн ил уурхай хүнд машин механизмын болон <i>Terex</i> маркийн (эсвэл түүнтэй дүйцэх) автосамосвалын дагалдах</li> </ul>



	<p>сэлбэг эд анги, материалыг худалдан борлуулах, дагалдах үйлчилгээ үзүүлэх албан ёсны дистрибьютер (гэрээт борлуулагч)-ийн зөвшөөрөл (үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ, эсхүл үйлдвэрлэгчээс энэ тухай гаргасан албан бичиг)-ийг ирүүлэх.</p> <ul style="list-style-type: none"> <li>- техникүүдийн төрөл бүрийн үйлчилгээ, засварын ажил гүйцэтгэх засварын газрын зөвшөөрөл, танилцуулга, хүчин чадал, хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл</li> <li>- Туршлагыг нотлох зорилгоор ижил төстөйд хамааралтай гэрээ, үйлчлүүлэгчийн тодорхойлолт (эсхүл бараа хүлээлцсэн болон гэрээ дүгнэсэн акт байж болно)-ын эх хувиас татсан хуулбар.</li> <li>- Оролцогчийн туршлагыг харуулах заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн маягтын дагуу бэлтгэсэн мэдээлэл;</li> </ul>
<b>ТШЗ 19.3</b>	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <b>“Шаардахгүй”</b>
<b>ТШЗ 21.6</b>	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“Тохируулахгүй тогтмол байна”</b>
<b>ТШЗ 24.1</b>	Тендерийн баталгааны дүн: <b>Төсөвт өртгийн 0.5 хувь.</b>
<b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b>	
<b>ТШЗ 25.5</b>	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p>Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ. Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн эрх бүхий этгээд баталгаажуулсан байна.</p> <p>Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалтыг Маягт 7-ын дагуу ирүүлнэ.</p> <p>Маягт-7-д ороогүй бусад файл, мэдээллийг цахим системд “Нууцлахгүй” төлөвтэйгээр илгээнэ.</p> <p>Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам”-ын дагуу цахим системд баталгаажсан чадавх, туршлагыг нотлох мэдээлэл, баримт бичгээс ТӨХ-д заасан шаардлагатайг сонгож, тендерийн хамт илгээх;</p>
<b>ТШЗ 26.1</b>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <b>2024 оны 3 дугаар сарын 28-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>09 цаг 00 минут</b></p>
<b>ТШЗ 26.2</b>	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: <b>2024 оны 3 дугаар сарын 28-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>09 цаг 10 минут</b></p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: <b>www.tender.gov.mn</b> цахим системээр нээнэ.</p>
<b>Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ</b>	
<b>ТШЗ 31.1</b>	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг:

	Шаардахгүй
<b>ТШЗ 32.1</b>	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: <b>“Үгүй”</b>
<b>Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>	
<b>ТШЗ 37.1+++</b>	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <b>“Тийм”</b> <i>Тендерт шалгарч, гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд тухайн жилд санхүүжүүлэх нийт төсөвт өртгийн 3 хувиар тооцож, хуулийн 42.3-т заасан хэлбэрээр гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ</i>
<b>Ё. БУСАД</b>	
<b>ТШЗ 38.1</b>	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: <b>“Үгүй”</b>

**III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА**  
**ТЕХНИКҮҮДИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТ ЗАСВАР, ҮЙЛЧИГЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ**  
**ТЕХНИКИЙН ДААЛГАВАР**

Тендерийн код: МРЦМ/20240101296

Багцын нэр: Техникуудийн төлөвлөгөөт засвар, үйлчилгээний ажил

Багц 1: TEREX TR60 автосамосвал, LIEBHERR R966, R976, R9100B-(2 нэгж) экскаваторууд, PR776 бульдозер техникийн засвар, үйлчилгээ, сэлбэг, материал, ажил үйлчилгээ авах

**АЖЛЫН ДААЛГАВАР:**

№	Ажлын даалгаварын хамрах хүрээн дэхь нэр томъёо	Хамрах хүрээний холбогдох тайлбар (норм, тоо хэмжээ, хугацаа, хуваарь)
<b>I.</b>	<b>Мэдээлэл:</b>	
1	Ажил гүйцэтгэх үндэслэл	“Монголросцветмет” ТӨҮГ-н 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
2	Хөрөнгө оруулагч (захиалагч) байгууллага	“Монголросцветмет” ТӨҮГ (“Бор-Өндөр” УБҮ)
3	Холбогдох хууль эрх зүйн заалтууд	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” (шинэчилсэн найруулга), 33 дугаар зүйлийн заалтууд
4	Засварын ажил гүйцэтгэх шаардлага, дүрмийн заалтууд	1. Зам, тээврийн сайдын 2016 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 90 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт “ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСВАР ХИЙХ ЖУРАМ” 2. Үйлдвэрлэгчийн засвар үйлчилгээ хийх шаардлагад нийцүүлэх 3. “Бор-Өндөр” УБҮ-ийн Авто тээврийн цехийн Terex TR60 маркийн автосамосвал-(16 нэгж), LIEBHERR R966, R976, R9100B-(2 нэгж) экскаваторууд, PR776 бульдозер ТЗҮ хийх батлагдсан стандартыг мөрдлөг болгох
5	Засварын нөхцөл	Уул уурхайн нөхцөлд техникуудийг уурхайн нутаг дэвсгэрт ТЗҮ-д хамруулах
6	Үйлчилгээ хийгдэх байршил	Монгол улс, Хэнтий аймаг, Бор-Өндөр сум, Бор-Өндөр УБҮ, Автотээврийн цех, Баргилтын ил уурхай
7		Төлөвлөгөөт засвар, үйлчилгээний ажил гүйцэтгэгч талаас TEREX TR60 маркийн автосамосвал, LIEBHERR R966, R976, R9100B-(2 нэгж) экскаваторууд, PR776 бульдозерын техникийн үйлчилгээний тос, тосолгооны материал, шүүр, ремень-оосор, нягтруулагч резин зэргийг хуваарь, төлөвлөгөөний дагуу солих, ТЗҮ-г гүйцэтгэх бараа материал бүхий ажил үйлчилгээ байна. 1. Сар бүр техник үйлчилгээний график төлөвлөгөө гаргах 2. Агуулахдаа сэлбэг, материалын болон тос, тосолгооны бэлэн нөөц нь захиалагчийн техник тус дээр хэрэглээний 30%-аас багагүй

	Төлөвлөгөөт засвар, үйлчилгээний ажил гүйцэтгэх тухай (хуваарь, төлөвлөгөө, бичиг баримтын бүртгэл, тайлан гаргах)	<p>хэмжээгээр бэлэн байх</p> <ol style="list-style-type: none"> <li>3. ТЗҮ 250 мотоциг, 500 мотоциг, 1000 мотоциг, 2000 мотоцигийн үечлэлээр үйлчилгээг үйлдвэрлэгчийн шаардлагын дагуу хийж гүйцэтгэх</li> <li>4. 1000 мотоциг тутамд тээврийн хэрэгслүүдэд төлөвлөгөөт үзлэг хийх, техникийн байдлаас хамаарсан, болзошгүй гэмтлээс урьдчилан сэргийлсэн шаардлагатай сэлбэгийн жагсаалт бүхий тайлан үйлдэж танилцуулах</li> <li>5. 4000 мотоциг тутамд хөдөлгүүрийн болон бусад системийн тосны дээж авч шинжилгээнд оруулж эд анги, агрегатын техникийн байдлын шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах</li> <li>6. Шаардлагатай бол “Тосны шинжилгээ”-ний үр дүнгээс үндэслэсэн, болзошгүй гэмтлээс урьдчилан сэргийлэх шаардлагаар сэлбэгийн жагсаалт бүхий тайлан үйлдэж танилуулах</li> <li>7. Техникүүдийн эд ангиудад урьдчилан сэргийлэх үзлэг тогтмол хийх (дизель хөдөлгүүр, хурдны хайрцаг, хүч дамжуулах хойд редуктор болон ступиц захын дамжуулагч, үндсэн рам, цахилгаан тоноглол, удирдлагын механизм, мэдээлэх самбар зэрэг эд ангиуд хамаарна)</li> <li>8. Техник үйлчилгээ болон засварын дараа мэдээлэх хуудас буюу репорт үйлдэж танилцуулж байх</li> <li>9. Сар бүрийн техникийн үйлчилгээний тайлангийн нэгтгэл гаргаж хамтран баталгаажуулж байх</li> <li>10. Засвар, техник үйлчилгээний сэлбэг, материалын зарцуулалтын тайлан өгөх</li> <li>11. Засвар, техник үйлчилгээний тос, тослох материалын зарцуулалтын тайлан өгөх</li> </ol>
8	Төлөвлөгөөт засвар, үйлчилгээний ажлын эзлэхүүн, хуваарь, хугацаа	<ol style="list-style-type: none"> <li>1. Техник үйлчилгээг захиалагчийн шаардлагаар 1 жилийн хугацаанд нэгж техникийн ажиллах 6000 мотоцигаар тооцож техникийн төлөвлөгөөт засвар, үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэнэ. Техникүүдийн ашиглалтын гүйцэтгэл 6000 мотоцигийг дуустал хугацаанд техникийн үйлчилгээг үргэлжлүүлэн хийж гүйцэтгэнэ.</li> <li>2. Нэгж техникт “Төлөвлөгөөт засвар, үйлчилгээний ажил”-ын гүйцэтгэл нь доорхи давтамжаар хийгдэнэ. Үүнд: ТЗҮ 250 мотоцигийн үйлчилгээ, дагалдах ажилбарууд 12 удаа, ТЗҮ 500 мотоцигийн үйлчилгээ, дагалдах ажилбарууд 6 удаа, ТЗҮ 1000 мотоцигийн үйлчилгээ, дагалдах ажилбарууд 3 удаа, ТЗҮ 2000 мотоцигийн үйлчилгээ, дагалдах ажилбарууд 3 удаа, ТЗҮ 6000 мотоцигийн үйлчилгээ, дагалдах ажилбарууд 1 удаа хийгдэнэ. Техник үйлчилгээний ажлын даалгаварын дэлгэрэнгүй хэсэгт тусгагдсан нэмэлт ажилбарыг хийж гүйцэтгэнэ.</li> <li>3. Нэмэлтээр: Ажил гүйцэтгэгч нь “Төлөвлөгөөт засвар, үйлчилгээний ажил” гүйцэтгэх хугацаанд техникүүдийн хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх, техникт үүссэн урсгал хэлбэрийн засварын ажлыг (засварлагдах ба бэлэн сэлбэгийг угсрах эвдрэл, гэмтэл засах) цаг тухайд засварлах үүрэг хүлээж ажиллана. Дизель хөдөлгүүр, хурдны хайрцагны тогтсон хугацааны засвар, үйлчилгээг хийж гүйцэтгэнэ. Дистрибьютер байгууллагаар хийлгүүлж болох ба баталгааг ирүүлэх үүрэгтэй.</li> </ol>
5	Ажил гүйцэтгэх байгууллагад тавигдах шаардлага, эрх үүрэг	<ol style="list-style-type: none"> <li>1. Засвар, техникийн үйлчилгээ үзүүлэх иж бүрэн мэргэжлийн баг сар бүр батлагдсан хуваарийн дагуу төлөвлөгөөт засвар, үйлчилгээний ажил ирж хийж гүйцэтгэх.</li> <li>2. Засвар, техникийн үйлчилгээ үзүүлэх иж бүрэн мэргэжлийн баг ажиллах үед гарсан шууд болон шууд бус зардлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.</li> <li>3. Техникийн үйлчилгээ хоорондын хугацаанд нэмэлтээр хэрэглэх тос, гэнэтийн төлөвлөөгүй байдлаар солигдох шүүр, ремень, нягтруулагч</li> </ol>

		<p>резинийг солих үүрэг хүлээнэ.</p> <ol style="list-style-type: none"> <li>Техникийн үйлчилгээ, засварын ажлыг хурдан шуурхай, баталгаатай хийж гүйцэтгэх</li> <li>Үзлэгээр илэрсэн гэмтлийг засварлах арга хэмжээ авах, шинээр сэлбэг, эд анги солих ажлуудад хамтарч угсралт хийх, зааварлах</li> <li>Техникийн үйлчилгээ, засварын ажлын хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бэлэн байлгах</li> <li>Техникийн үйлчилгээ, засварын ажлын баталгааг хариуцах</li> <li>Захиалагчийн зүгээс бэлтгэсэн талбай, засварын байранд техникийн үйлчилгээ засварыг хийж гүйцэтгэнэ.</li> <li>Уурхайн нутаг дэвсгэр, үйлдвэрийн хэмжээнд ХАБЭА-н дүрэм, журамд нийцүүлэн ажиллах, зааварчилгаа авах үүрэгтэй</li> <li>Ажлын байран дахь үйл ажиллагааны үеийн ХАБЭА-н хэрэгжүүлэх, хянах арга хэмжээг гүйцэтгэгч тал хариуцаж ажиллана.</li> </ol> <p>Техникийн үйлчилгээ, засварын ажлын гүйцэтгэх, хамрах хүрээнд үйлдвэрийн, уурхайн удирдлага, холбогдох инженер техникийн ажилтнуудад мэдээлэх, санал солилцох, шаардлага хүргүүлэх, хамтран шийдвэр гаргах үүрэгтэй</p>
6	Нийлүүлэх бараа, материалын тухай	<ol style="list-style-type: none"> <li>Техникийн үйлчилгээнд ашиглах тос, тосолгооны материалыг техникийн нийлүүлэгчээс санал болгож одоо хэрэглэж байгаа TOTAL үйлдвэрийн тос, тосолгооны хэрэгслийг сонгож ашиглана.</li> <li>Тос, тосолгооны хэрэгслийн нийлүүлэлтийн хэмжээ: <ul style="list-style-type: none"> <li>Өвлийн улиралд ашиглах хэмжээг 10-р сарын 15-аас дараа жилийн 4-р сарын 15 хүртэлх хугацаанд буюу 5 сарын хэрэглээгээр тооцно.</li> <li>Зуны улиралд ашиглах хэмжээг 4-р сарын 15-аас дараа жилийн 10-р сарын 15 хүртэлх хугацаанд буюу 7 сарын хэрэглээгээр тооцно.</li> </ul> </li> <li>Техник үйлчилгээнд шаардлагатай тос, тослох материалыг 2024 оны 06-р сарын 01 хүртэлх хугацаанд захиалагчийн нөөцөөс хэрэглэхээр тооцно.</li> </ol> <p>Техник үйлчилгээнд шаардлагатай үйлчилгээний шүүр, ремень, нягтруулагч резин зэрэг материалуудыг гэрээ байгуулсан цагаас нийлүүлж эхэлнэ. Тухайн техникийн мотоцагийн үзүүлэлтээр хийгдэх үйлчилгээнд тохируулан техникийн үйлчилгээг хийж гүйцэтгэж эхэлнэ.</p>
7	Захиалагчийн талын эрх, үүрэг	<ol style="list-style-type: none"> <li>Техникийн үйлчилгээний сэлбэг, материал, тос тосолгооны хэрэгслийг өөрийн агуулахад байршуулах, хадгалах, тогтсон журмын дагуу олгох</li> <li>Засварын үед шаардлагатай техник хэрэгслийг өөрийн боломжит нөхцлөөр ашиглуулах, түрээслэх</li> <li>Ажил гүйцэтгэгч талын бүх ажилчдад уурхайн нутаг дэвсгэр, үйлдвэрийн хэмжээнд ХАБЭА-н зааварчилгаа өгөх, дүрэм, журамд нийцүүлэн ажиллуулахыг хариуцах үүрэгтэй</li> <li>Захиалагчийн төлөөлөгч нь техникийн үйлчилгээний сэлбэг, материал, тос тосолгооны хэрэгслийн зарцуулалт, хийгдэж буй үйлчилгээний болон засварын ажилд хяналт тавих</li> </ol>

TEREX TR60 автосамосвал

№	Ажлын даалгаварын хамрах хүрээнд дэхь нэр томъёо	1. Хамрах хүрээний холбогдох тайлбар (норм, тоо хэмжээ, хугацаа, хуваарь)
---	--	---

1	Техникийн мэдээлэл	2. Марк – TEREХ TR60 3. Үйлдвэрлэсэн огноо – 2022 4. Ашиглалтад орсон огноо – 2023.02 5. Байдал – шинэ 6. Зориулалт - Ачаа /Ил уурхайд хөрс хүдэр тээвэрлэх/ 7. Бүх жин – 101250 кг 8. Өөрийн жин – 41250кг 9. Хөдөлгүүрийн модель – Cummins QSK19-C700 /цуваа 6, 522кВт 700Нр / 10. Хурдны хайрцаг – Allison M6610AR /автомат, урагш 6 ухрах 1 / 11. Өнгө – Цагаан 12. Дугуйн томъёлол 4*2 13. Дугуй – 24.00R35				
2	Техникийн ашиглалтын байдал	№	Марк	Арлын дугаар	Улсын дугаар	Ажилласан цагийн үзүүлэлт (2024.02.07-ны байдлаар)
		1	TR60	NHLTVAAAANB000392	27-80ХЭН	6024
		2	TR60	NHLTVAAALNB000393	27-68ХЭН	6031
		3	TR60	NHLTVAAAHNB000394	27-66ХЭН	5913
		4	TR60	NHLTVAAAENB000395	27-65ХЭН	5775
		5	TR60	NHLTVAAACNB000396	27-64ХЭН	6207
		6	TR60	NHLTVAAAHNB000413	27-63ХЭН	6070
		7	TR60	NHLTVAAAENB000414	27-62ХЭН	6020
		8	TR60	NHLTVAAACNB000415	27-61ХЭН	2837
		9	TR60	NHLTVAAATNB000416	27-87ХЭН	5993
		10	TR60	NHLTVAAAPNB000417	27-86ХЭН	5611
		11	TR60	NHLTVAAAКNB000418	27-85ХЭН	5654
		12	TR60	NHLTVAAAJNB000419	27-84ХЭН	6043
		13	TR60	NHLTVAAAPNB000420	27-69ХЭН	3100
		14	TR60	NHLTVAAAКNB000421	27-83ХЭН	4744
		15	TR60	NHLTVAAAJNB000422	27-82ХЭН	5907
		16	TR60	NHLTVAAACNB000423	27-81ХЭН	5890
3	Төлөвлөгөөт засвар, үйлчилгээний ажлын эзлэхүүн, хуваарь, хугацаа	1. Дизель хөдөлгүүр, хурдны хайрцагны тогтсон хугацааны засвар, үйлчилгээг хийж гүйцэтгэнэ. Дистрибьютер байгууллагаар хийлгүүлж болох ба баталгааг ирүүлэх үүрэгтэй.				
4	Нийлүүлэх бараа, материалын тухай	1. Техникийн үйлчилгээний сэлбэг, материал нь TEREХ үйлдвэрлэгчээс нийлүүлэгдсэн жинхэнэ үйлдвэрийн бараа байна.				
<b>Техник үйлчилгээний ажлын даалгаврын дэлгэрэнгүй:</b>						

5

Техник  
үйлчилгээ-нд  
хийх ажилбар**1. 250 мотоцигийн үечлэлд хийх техник үйлчилгээ.**

Гүйцэтгэх ажил		Нэг удаа солих хэмжээ	Эдийн дугаар, төрөл
Хөдөлгүүр	Тос солих	70л	Total engine oil 10W30/15W40
	Тосны шүүр	2 ширхэг	15501271 / LF14000NN
	Түлшний шүүр	2 ширхэг	15503187 / FF5782NN
	Агаар шүүгч гадна тал	2 ширхэг	15270188 / AF25454
Автомат өтгөн тос цэнэглэх		5 кг	Total grease EP2/EP0
Автомат тосолгооны цэг тослох боломжгүй 6 цэгт тосолгоо хийх			
Автомат өтгөн тос цэнэглэгчийн ажиллагааг шалгах өтгөн тос хүрэх цэгүүдэд үзлэг хийх			
Дугуйн хийн даралтын шалгах			
Эд ангиудын бэхэлгээ, суурь, палецны түгжээ, гидрийн систем, хөргөлтийн системийн ажиллагаанд холболтын битүүмж чангалгаанд үзлэг хийх			
Хурдны хайрцаг, хойд редуктор, захын дамжуулагч, хөргөлтийн систем, гидрийн системийн тосны түвшин шалгах			
<b>2. 500 мотоцигийн үечлэлд хийх техник үйлчилгээ.</b>			
Гүйцэтгэх ажил		Нэг удаа солих хэмжээ	Эдийн дугаар, төрөл
Хөдөлгүүр	Тос солих	70л	Total engine oil 10W30/15W40
	Тосны шүүр	2 ширхэг	15501271 / LF14000NN
	Түлшний шүүр	2 ширхэг	15503187 / FF5782NN
	Түлшний шүүр /нано/	1 ширхэг	15503184 / FS53015(Nano)
	Хөргөлтийн шингэний шүүр	1 ширхэг	15275737 / WF2075
	Агаар шүүгч гадна тал	2 ширхэг	15270188 / AF25454
	Агаар шүүгч дотор тал	2 ширхэг	15270189 / AF25468
Араат дамжуулга	Тос солих	2 л	Total gear oil 80W90
Автомат өтгөн тос цэнэглэх		5 кг	Total grease EP2/EP0

Автомат тосолгооны цэг тослох боломжгүй 6 цэгт тосолгоо хийх			
Автомат өтгөн тос цэнэглэгчийн ажиллагааг шалгах өтгөн тос хүрэх цэгүүдэд үзлэг хийх			
Дугуйн хийн даралтын шалгах			
Эд ангиудын бэхэлгээ, суурь, палецны түгжээ, гидрийн систем, хөргөлтийн системийн ажиллагаанд холболтын битүүмж чангалгаанд үзлэг хийх			
